

## Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээ #2

Энэхүү Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээг (цаашид “Гэрээ” гэх) 2017 оны 5-р сарын 9-ний өдөр дараах талуудын (хамтад нь Талууд, тусад нь Тал гэх) хооронд байгуулсан болно:

1. Ханбогд сумын Засаг Захиргаа (цаашид **Ханбогд сум**);
2. Ханбогд сумын багуудын малчдын төлөөлөгчид (цаашид хамтад нь **Малчдын төлөөлөгчид** гэх);
3. Оюу Толгой ХХК (цаашид **ОТ**).

### I. Гэрээний зорилго

- 1.1 Тус гэрээний зорилго нь Эрх Зүйн Хяналт, Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗХНЗОГ)-т 2013 оны 2 дугаар сард гаргасан малчдын гомдлыг барагдуулах Хавсралт 1-т заасан үйл ажиллагааг Талууд хамтран хэрэгжүүлэхэд оршино.

### II. Гомдлын танилцуулга

- 2.1 Олон Улсын Санхүүгийн Корпорацийн (ОУСК) санхүүгийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Өмнөговь аймгийн Ханбогд суманд хэрэгжиж буй Оюу Толгой төслийн нөлөөнд өртсөн өөрсдийгөө нутгийн уугуул иргэд<sup>1</sup> гэж үзэж буй орон нутгийн нүүдэлчин малчид “Оюу Толгой Хяналт” ТББ, Ханбогд сумын “Говийн Газар Шороо” орон нутгийн ТББ-ын дэмжлэгтэйгээр Дэлхийн Банкны Группын ОУСК болон Олон Талын Хөрөнгө Оруулалтын Баталгааны Агентлагтай (ОТХОБА) холбоотой асуудлаар хөндлөнгийн хараат бус хариуцлагын механизмын үйлчилгээ үзүүлдэг Эрх Зүйн Хяналт, Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗХНЗОГ)-т Ундайн голын гольдролыг өөрчлөх төслийн нөлөөллийн асуудлаар 2013 оны 2-р сард гомдол гаргасан.
- 2.2 Гомдол гаргагчдын бүрэлдэхүүнд тухайн үеийн Ханбогд сумын ИТХ-ын төлөөлөгч, Жавхлантагчийн хурлын дарга нар орсон. Гомдол гаргагчид нь голын гольдролыг өөрчлөх нь үндэсний уламжлалт нүүдлийн мал аж ахуй, тэдний амьжиргаанд аюул учруулна гэж үзсэн бөгөөд ОТ-г голын голидрол өөрчлөх ажлаа зогсоохыг хүссэн юм. Ялангуяа ийнхүү гольдрол өөрчилснөөр хэд хэдэн усан хангамжийн системийг ширгээж, бэлчээрийн үржил шимийг муутган, ой модны усан хангамж татрахад хүргэх ба энэ голыг хүн зон тахин шүтдэг тул ёс заншилд ч нөлөөлнө хэмээн тэдний санаа нь зовж байсан.
- 2.3 Эрх Зүйн Хяналт, Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗХНЗОГ) нь уг гомдлыг үнэлгээний шалгуурыг хангасан гэж үзсэн бөгөөд 2013 оны эхээр хийгдсэн үнэлгээний үйл явцын хүрээнд Гомдол гаргагчид болон Оюу Толгой компани нь ЭЗХНЗОГ-ын чиглүүлэл, туслалцаатайгаар сайн дурын үндсэн дээр гомдолд тусгагдсан асуудлыг хэлэлцээрийн замаар шийдэхээр хамтран ажиллахыг зөвшөөрсөн.

### III. Маргааныг шийдвэрлэх үйл явц

- 3.1 Талууд 2013 оны 3-р сарын 15-наас 2017 оны 5-р сарын 9-ний хооронд ЭЗХНЗОГ-ын эвлэрүүлэн зуучлалын туслалцаатайгаар гомдлын маргааныг шийдвэрлэх үйл явцад оролцов.
- 3.2 Ханбогд сум, Малчдын төлөөлөгчид (МТ) болон ОТ-н хооронд Гурван Талт Зөвлөл (ГТЗ) байгуулах зорилгоор Талууд Харилцан Ойлголцлын Санамж Бичгийг 2015 оны 6-р сарын 8-нд байгуулж гарын үсэг зурсан юм.

<sup>1</sup>2013 оны 2-р сард малчдын гаргасан гомдолд дурдсан уг хэллэгийг ашиглав.

ГТЗ нь ЭЗХНЗОГ-т гаргасан гомдлуудтай холбоотой малчид, бэлчээр, ус болон холбогдох бусад асуудал, гомдол, санал санаачилга эсвэл зөвлөмжүүдийг авч үзэх, анхаарал хандуулах, шийдвэрлэх, тэдгээрийн талаар мэдээлэл солилцох, тэдгээрт холбогдуулан санал, зөвлөмжүүд гаргах, түүнийг хэрэгжүүлэх, зохих эрх бүхий байгууллагуудад уламжлах чиг үүрэгтэй болно.<sup>2</sup>

- 3.3 Маргааныг шийдвэрлэх үйл явцын хүрээнд Талууд баримтыг хамтран олж тогтоох үйл явцыг эхлүүлж, Ундай гол, Бор Овоогийн Задгай, Халив-Дугатын гол гэсэн гурван чухал усны эх үүсвэрт Оюу Толгойн Төслөөс учруулж буй нөлөөллүүдэд үнэлгээ хийж, тэдгээр нөлөөллүүд малчдын бэлчээр, усны хүртээмж, усны чанарт ямар хохиролтой болохыг тогтоох, нэн ялангуяа Оюу Толгой компаниас Ундай голын гольдролыг өөрчлөх, Бор овоогийн задгайг шилжүүлэх, хаягдал агуулах байгууламж, чулуун хаягдлын овоолгын нөлөөллүүдийн талаар ОТ-н өгсөн баримт мэдээлэл үнэн зөв байсан эсэх, түүнчлэн малчдын бэлчээр, усны хүртээмж, усны чанарт учрах нөлөөллүүдээс зайлсхийх буюу багасгах өөр хувилбар, өөрчлөлт эсвэл бууруулах нэмэлт арга хэмжээ авч болох байсан эсэх тухай үнэлгээ хийх Хөндлөнгийн Шинжээчдийн Багийг (ХШБ)-ыг Талууд хамтран сонгож, ажиллуулсан болно.<sup>3</sup> ХШБ нь дээрх ажлыг 2 үе шаттайгаар гүйцэтгэж, ажлынхаа эцсийн тайлан болон зөвлөмжүүдийг<sup>4</sup> 2017 оны 1-р сард Талуудад илгээсэн бөгөөд Талууд зөвлөмжүүдийг энэхүү Гэрээнд дурдсан байдлаар хүлээн зөвшөөрч, хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллахаар тохирсон болно.

#### IV. Гомдлыг шийдэхээр тохиролцсон байдал

- 4.1 Талууд нь гомдлын асуудлуудаар зөвшилцөлд амжилттай хүрч, Хавсралт 1-д дурдсан Үйл Ажиллагааны Дэлгэрэнгүй Төлөвлөгөөг хэрэгжүүлж ЭЗХНЗОГ-т гаргасан гомдлын асуудлуудыг шийдэхээр тохиролцов.
- 4.2 Энэхүү Гэрээний Хавсралт 1-т ОТ дангаараа буюу хамтран хариуцаж хийхээр тохирсон бүх ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардал, санхүүжилтыг ОТ компани хариуцна.
- 4.3 Талууд энэхүү Гэрээнд заасан асуудлаар бүхэлд нь харилцан тохиролцсон бөгөөд Гэрээнд тусгасан заалтууд нь эцсийнх болно. Энэхүү Гэрээний хэрэгжилтийг Талууд бүрэн гүйцэд, үр дүнтэй, хангалттай хэрэгжүүлсэн гэж дүгнэсний дараа аль нэг тал нь Гэрээнд заасан асуудлаар маргаан, гомдол гаргахгүй болохыг Талууд харилцан тохиролцсон болно.
- 4.4 Энэхүү Гэрээний Хавсралт 1-т тохирсон үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжилтийн үр дүнд үүсч болзошгүй шинэ гомдол, маргаан нь тус Гэрээнээс салангид тусдаа гэж үзэх бөгөөд энэхүү Гэрээнд нэмж оруулахгүй болохыг Талууд харилцан тохиролцсон болно.

#### V. Энэхүү Гэрээг хэрэгжүүлэх тухай

- 5.1 Талууд Гэрээний Хавсралт 1-т тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд харилцан бие биедээ хүндэтгэлтэй, дэмжиж ажиллах бөгөөд аль нэг Талын хэрэгжүүлж буй ажлыг аюулгүй (бусдад хор хөнөөл учруулахгүй), үр өгөөжтэй байхыг чухалчилна.

<sup>2</sup>Турван Талт Зөвлөл байгуулсан Харилцан Ойлголцлын Санамж Бичгийг үзнэ үү. [http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/FinalSignedMoUwithAnnexures\\_MON.pdf](http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/FinalSignedMoUwithAnnexures_MON.pdf)

<sup>3</sup>ХШБ-ийн Ажлын Даалгаврыг үзнэ үү. □ [http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/FINALMON\\_ToRfor\\_UndaiRiverDiversionComplaint\\_CAO\\_IER.pdf](http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/FINALMON_ToRfor_UndaiRiverDiversionComplaint_CAO_IER.pdf) □

<sup>4</sup>ХШБ-ийн I үе шатны ажлын тайлангийн хураангуй болон зөвлөмжүүдийг [http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/MON\\_RecommendationstoStakeholders\\_edit\\_Jan11\\_2015.pdf](http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/MON_RecommendationstoStakeholders_edit_Jan11_2015.pdf) □ хаягаар, ХШБ-ийн II үе шатны ажлын тайланг бүрэн эхээр нь [http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/MDTIER\\_FINALREPORT\\_MON\\_January292017\\_001.pdf](http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/MDTIER_FINALREPORT_MON_January292017_001.pdf) □ хаягаар орж үзнэ үү.

- 5.2 Талууд энэхүү Гэрээнд тусгасан бүх нөхцлийг хэрэгжүүлнэ. Талууд шаардлагатай тохиолдолд харилцан зөвшилцөж, тохиролцон нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ. Ийм нэмэлт өөрчлөлт нь тус Гэрээний салшгүй хэсэг болно.
- 5.3 Энэхүү Гэрээний Хавсралт 1 буюу Үйл Ажиллагааны Дэлгэрэнгүй Төлөвлөгөө нь Талуудын харилцан тохиролцож хэрэгжүүлэхээр тодорхойлсон үйл ажиллагааны хамрах хүрээ, хариуцах Тал, хэрэгжүүлэх хугацаа зэргийг тусгасан бөгөөд бүх хавсралтууд нь тус Гэрээний салшгүй хэсэг байна.
- 5.4 Энэхүү Гэрээ нь бүх Талуудын ашиг сонирхолд нийцсэн бөгөөд Гэрээний хавсралтаар оруулсан үйл ажиллагааны хэрэгжилтийг амжилттай хангахад чиглэсэн Талуудын үүрэг амлалт мөн болно. Талууд нь Гэрээг хэрэгжүүлэхэд үнэнч шударгаар, идэвхитэй хамтран ажиллана.
- 5.5 Энэхүү Гэрээний Хавсралт 1-т заасан бүх үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж дууссаны дараа тус Гэрээ нь дуусгавар болно.
- 5.6 Талууд нь энэхүү Гэрээний Хавсралт 1-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ малчид болон бусад оролцогч талын оролцоог хангаж, зөвлөлдөж ажиллахыг чухалчилна.

#### VI. Талуудын хоорондын харилцаа холбоо

- 6.1 Энэхүү Гэрээг хэрэгжүүлэхэд ГТЗ нь өөрийн Дүрмийн хүрээнд<sup>5</sup> холбогдох талуудад нээлттэй харилцаа холбоог хангаж ажиллана. Гомдол гаргагчид нь зөвлөлийн дүрэмд заасны дагуу ГТЗ-ийн хуралд оролцож болох бөгөөд аливаа асуудлаар санал сэтгэгдлээ илэрхийлэх боломжтой байна.
- 6.2 Талууд энэхүү Гэрээг олон нийтэд ил тод, нээлттэй байлгахыг зөвшөөрөв.
- 6.3 Энэхүү Гэрээний хэрэгжилтийн талаар аливаа мэдээлэл, мэдэгдэл хийх тохиолдолд Талууд харилцан тохирсон, хамтарсан мэдэгдэл бэлтгэж ашиглахдаа ГТЗ-н дүрмийг баримтална.
- 6.4 Талууд нь энэхүү Гэрээний хэрэгжилтийн талаар үнэн бодит мэдээллийг оновчтой эх сурвалжаар дамжуулан цаг хугацаанд нь Ханбогд сумын малчид, иргэдэд хүргүүлэх замаар үүсч болзошгүй аливаа үл ойлголцол, ташаа мэдээлдээс сэргийлж ажиллана.

#### VII. Мониторинг

- 7.1 Талууд тус Гэрээний хэрэгжилтийг гэрээнд гарын үсэг зурснаас хойш 12 сарын хугацаанд ЭЗХНЗОГ-ын үйл ажиллагааны журмын дагуу ЭЗХНЗОГ-аар мониторинг хийлгэнэ. Гэрээний хэрэгжилтийн мониторингийг утсаар эсвэл и-мейлээр эсвэл харилцаа холбооны бусад хэлбэрээр буюу шаардлагатай тохиолдолд биечлэн танилцах замаар гүйцэтгэхийг зөвшөөрөв.
- 7.2 Дээр дурьдсан 7.1 заалтад тусгасан мониторинг хийх хугацааны төгсгөлд ЭЗХНЗОГ нь Гэрээ амжилттай хэрэгжиж байгаа эсэх талаар ГТЗ-ийн дүгнэлтэнд үндэслэн мониторингийн үнэлгээ, дүгнэлт гаргана. ЭЗХНЗОГ-ын дүгнэлтээр Гэрээг амжилттай хэрэгжиж байгаа гэж мониторингийн үнэлгээ, дүгнэлт гаргасан тохиолдолд Гомдлын Маргааныг хаана. Гэрээний хэрэгжилт амжилтгүй гэж мониторингийн үнэлгээ, дүгнэлт гаргасан тохиолдолд мониторингийн хугацааг сунгаж, Гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар ЭЗХНЗОГ-ын мониторингийг үргэлжлүүлнэ.

<sup>5</sup>Гурван Талт Зөвлөл байгуулсан Харилцан Ойлголцлын Санамж Бичиг, ГТЗ-ийн дүрмийг үзнэ үү. [http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/FinalSignedMoUwithAnnexures\\_MON.pdf](http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/FinalSignedMoUwithAnnexures_MON.pdf)

- 7.3 ЭЗХНЗОГ-ын мониторинг хийх явцад Талуудын хооронд энэхүү Гэрээтэй холбоотой аливаа маргаан эсвэл үл ойлголцол гарсан тохиолдолд ЭЗХНЗОГ-ын эвлэрүүлэн зуучлалын багт аливаа Тал хандаж туслалцаа хүсч болно. Энэ тохиолдолд ЭЗХНЗОГ-ын эвлэрүүлэн зуучлалын баг тухайн маргаан эсвэл үл ойлголцлыг шийдвэрлэхийн тулд Талуудын уулзалтыг зохион байгуулж чиглүүлэн ажиллана.
- 7.4 Гомдлыг хаасны дараа ГТЗ нь малчид, бэлчээр, ус болон холбогдох бусад асуудал, гомдол, санал санаачлага эсхүл зөвлөмжүүдийг авч үзэх, анхаарал хандуулах, шийдвэрлэх, тэдгээрийн талаар мэдээлэл солилцох, тэдгээрт холбогдуулан санал, зөвлөмжүүд гаргах, түүнийг хэрэгжүүлэх, зохих эрх бүхий байгууллагуудад уламжлах чиг үүрэгтэй үргэлжлүүлэн ажиллана.<sup>6</sup>

**VIII. Бусад**

- 8.1 Гэрээг Монгол болон Англи хэл дээр тус бүр дөрвөн хувь үйлдэж хувийг Талуудад болон ЭЗХНЗОГ-д тус тус хүргүүлнэ.
- 8.2 Гэрээний англи хувь болон монгол эхийн хооронд зөрүү гарвал Гэрээний монгол эхийг баримтална.
- 8.3 Гэрээнийн гарчигуудыг Талууд гэрээний заалтыг ойлгох, хэрэглэхэд хялбар дөхөм байх үүднээс ашигласан бөгөөд Гэрээг тайлбарлахад аливаа нөлөө үзүүлэхгүй.
- 8.4 Гэрээг хэрэгжүүлэх явцад талуудын хооронд энэхүү Гэрээтэй холбоотой үл ойлголцол маргаан үүссэн тохиолдолд Талууд эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Эв зүйгээр тохиролцож чадаагүй тохиолдолд шүүхийн болон шүүхийн бус маргаан шийдвэрлэх хэрэгсэлд хандаж болно.

Талууд зөвшөөрч 2017 оны 5-р сарын 9-ний өдөр гарыг зөвшөөрч:

Ханбогд Сумыг төлөөлөн:  
 Ханбогд Сумын Иргэдийн  
 Төлөөлөгчдийн Хурлын Дарга  
 Ханбогд Сумын Засаг Дарга



Ханбогд Сумын Засаг Даргын Орлогч

Мал Эмнэлэг, Үржлийн Тасгийн Дарга

Байгаль орчны Хяналтын Улсын  
Байцаагч

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
төлөөлөгч

Баян багийн Засаг Дарга

Дашийн Хүрэлбаатар


Бат-Эрдэнийн Алтангэрэл


Батын Эрдэнэбаяр


Мижиддоржийн Мягмаржав


<sup>6</sup>Гурван Талт Зөвлөл байгуулсан Харилцан Ойлголцлын Санамж Бичгийг үзнэ үү. [http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/FinalSignedMoUwithAnnexures\\_MON.pdf](http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/FinalSignedMoUwithAnnexures_MON.pdf)


Ханбогд сумын Малчдыг төлөөлөн:


  
Лхамдооровын Батцэнгэл ←


  
Өөлийн Баттогтох ←


  
Долгорсүрэнгийн Намсрай ←

  
Чулууны Намнансүрэн ←


  
Данзаншадатын Наранхуу ←

  
Ганжуурын Мягмар ←

  
Төмөрмөнхийн Насанбуян ←


  
Цэвэгдэлгэрийн Гүнэмаа ←

Оюу Толгой ХХК-г төлөөлөн:


  
Шуркагийн Байгалмаа ←

Оюу Толгой ХХК-ийн Орон Нутгийн Харилцаа хариуцсан Ерөнхий Менежер


Оюу Толгой ХХК-ийн Орон Нутгийн Харилцаа, Түншлэл хариуцсан Менежер,

  
Осорлүрэвийн Цэрэннадмид ←

Оюу Толгой ХХК-ийн Байгаль Орчны асуудал хариуцсан Менежер

  
Нарангийн Эрдэнэбаяр ←


Оюу Толгой ХХК-ийн Хөдөлмөрийн Харилцаа хариуцсан Менежер

  
Лхаасүрэнгийн Мөнх-Оргил ←

Оюу Толгой ХХК-ийн Хангамжийн Хэлтсийн Менежер

  
Дэлгэрийн Амартүвшин ←

Оюу Толгой ХХК-ийн Орон Нутгийн Харилцааны Ажилтан

  
Сүхрагчаагийн Дорждэрэм ←

ЭЗХНЗОГ-ын эвлэрүүлэн зуучлагч Батсайханы Нандинчимэг болон Болдбаатарын Очирбат  нар байлцав. 

**Хавсралт 1. Гомдлыг (#2) шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэхээр тохирсон арга хэмжээнүүд**

ӨМНӨГОВЬ АЙМАГ, ХАНБОГД СУМ						
ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛ - 2017 оны 5-р сарын 9						
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТӨЛӨВЛӨГӨӨ						
№	Хийгдэх үйл ажиллагаа	Хэрэгжих хугацаа	Хариуцах тал	Үр дүнгийн гүйцэтгэлийн үзүүлэлт (КРД)	Тайлбар	Төрийн бодлого, хэрэгжиж буй хөтөлбөртэй уялдсан байдал
2013 оны 2-р сард гаргасан Ундайн голын голидрол өөрчилсөнтэй холбоотой гаргасан гомдлын асуудлыг шийдэхээр тохирсон ажлыг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөө						
1	Ундайн голын голидрол өөрчилсөнтэй холбогдуулан албан ёсоор малчдаас уучлал гуйж, уучлалын захидлыг олон нийтэд хэвлэх; (Хавсралт А)	2015 оны 3-р сарын 20	ОТ	Олон нийтэд нээлттэй хэвлэж танилцуулсан "Уучлал гуйсан захидал"	Хавсралт А	
2.	Уурхайн лицензтэй талбайд (УЛТ) байрлах нутгийн иргэдийн шүтдэг Бор Овоог хөндөхгүйн тулд ОТ-н хаягдал чулуулгын овоолгын зураг төслийг өөрчлөн боловсруулж Бор Овоог хөндөхгүй хэвээр үлдээх;	2016 оны 9 сарын 22	ОТ	Бор Овоог хөндөхгүйгээр өөрчилсөн хаягдал чулуулгын овоолгын төлөвлөгөө	Хуучин төлөвлөгөөг шинэ төлөвлөгөөтэй харьцуулж багалгаажуулах	
3.1	Бор Овоогийн шинэ Задгайг орон нутгийн малчидтай зөвлөлдөн тохирч, талууд Бор Овоогийн шинэ Задгайг ургамалжуулах ажлыг хамтран төлөвлөж хийх;	2016 оны 5 сараас 2018 оны 8-р сар	ОТ	Биологийн нөхөн сэргээлт бүрэн хийгдсэн тухай Аймгийн Уул уурхайн ашиглалт, дэд бүтэц, бусад үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг хүлээн авах ажлын хэсгийн акт	Явцын тайланг ГТЗ-ийн хурлаар жилд нэг удаа танилцуулах	
3.2	Ургамалжуулалтын төлөвлөгөөг малчидтай хамтран боловсруулж үйл ажиллагааг хэрэгжүүлж, үр дүнд шинжилгээ хийх		Н. Эрдэнэбаяр, ОТ			
3.3	Бор Овоогийн шинэ Задгайн хэсэгт Хуучин Бор Овоогийн Задгайн тухай мэдээлэл бүхий самбар байршуулах	2017 оны 3-р улиралд	О. Цэрэннадмид, ОТ	Байршуулсан мэдээллийн самбар	Самбарын текстийг ГТЗ, МТ-тай зөвлөлдөн боловсруулах	
4.	Бор Овоогийн Задгайн фото зургийг Сумын Музейд байрлуулахаар ОТ компани бэлтгэж Малчдын төлөөлөгчдөд хүлээлгэн өгөх;	2015 оны 3-р сарын 20	ОТ	Сумын музейд байрлуулсан Бор Овоогийн Задгайн фото зураг	2017 оны 6-р сарын ГТЗ-ийн хуралд сумын музейн эрхлэгч Р. Сонинболдыг урьж оролцуулан зургийг хүлээлгэж өгөх  Зургийн тайлбарыг бичиж хавсаргах (Ч.Намнансүрэн, МТ)	
5.1	Байгаль орчинд ногоон бүс нэмэгдүүлэхийн тулд 3 жилийн хугацаанд мод тарих – "Говийн төгөл" төслийг хэрэгжүүлэхэд зарцуулах 88 сая төгрөгийг санхүүжүүлэх; Төсөлд Ундайн гол дагуу нутагладаг малчдыг хамруулах	2016 оны 10 сараас 2019 оны 10 сар хүртэл	ОТ	1. УГ дагуу нутагладаг малчин өрхүүдээс 15-аас доошгүй өрхийг жил тус бүр хамруулсан байх 2. Нийт тарьсан модны ургацын хувь 75%-аас доошгүй хувь 3. Сумаас томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэж өгсөн	Гурван Талт Зөвлөлийн захиалгаар "Говийн Газар Шороо" ТББ хэрэгжүүлж байгаа  ГТЗ-ийн бүх гишүүд мод тарих үйл ажиллагааг эхлүүлэх	
5.2	Мод тарих үйл ажиллагааг эхлүүлэх, Говийн Төгөл төслийн тухай танилцуулга бүхий самбар байрлуулах	2017 оны 5-р сарын 2	ГТШ ТББ/ГТЗ		Төслийн явцын тайланг жилд 2 удаа ГТЗ-д танилцуулах	

5.3	Говийн төгөл төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, холбогдох тайланг гаргаж нийтэд танилцуулж байх	2016 оны 10 сараас 2019 оны 10 сар хүртэл	ГГШ/ГТЗ	акт		
6.	УЛТ дотор Ундай голын урсгал хаагдсан гурван хэсэг газарт (1) ажилчдын кемпийн баруун талын сайран дээрээс кариер авсан газар, (2) дулааны станц руу ордог зам, (3) Ундайн голын голидрол өөрчилсөн шинэ сувгийн хэсэгт Ундайн голыг дахин чөлөөтэй урсахын тулд боломжит бүх арга хэмжээ авах;	Борооны улиралд	ОТ	(1) ажилчдын кемпийн баруун талын сайран дээрээс кариер авсан газар, (2) дулааны станц руу ордог зам, (3) Ундайн голын голидрол өөрчилсөн шинэ сувгийн хэсэгт үерлэхэд Ундайн голын ус чөлөөтэй урсах нөхцөл бүрдсэн байх	Бороо орж, Ундайн гол үерлэсний дараа МТ (орчны малчдын хамт) УЛТ-д орж гол чөлөөтэй урсаж буйг гэрчилж баримтжуулах	
7.	Гүехэн гар худгууд барих хөтөлбөрийн хэлбэрээр нийтийн нөхөн олговор олгох; малчид нүүдлээ хийн, бэлчээрийн нөөцийг ашиглахыг дэмжин, малчдад уламжлалт амьжиргаагаа үргэлжлүүлэн эрхлэх боломжийг хэвээр үлдээхийн тулд худгуудыг 4 багийн нутагт тараан байрлуулах. Шинэ худгуудыг бүтээмж сайтай, одоо байгаа худгуудад нөлөөлөхгүй байлгахын тулд тэдгээрийн байршил <i>бэлчээрийн доорх усны нөөцийн судалгаанд</i> үндэслэн гаргах шаардлагатай ба түүнчлэн зэрлэг амьтдад нөлөөлөл учруулах эсвэл тэднээс ирэх нөлөөллийн тухайд малчид санаа зовдог гэх мэт малчдын санаа бодлыг тусгах хэрэгтэй;	Бэлчээрийн доорх усны нөөцийн судалгааны дараа буюу шинэ худгийн хөтөлбөр 2018 оноос эхлэх	ОТ/ГТЗ	Бэлчээрийн доорх усны нөөцийн судалгаанд үндэслэн ГТЗ-ийн тохиролцож шинээр гаргасан худгийн тоо ...	Ажлын даалгаврыг ГТЗ-өөр хэлэлцүүлэх	Бэлчээрийн доорх усны нөөцийн судалгаа, бэлчээрийн төлөвлөгөө, Сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөө, Ханбогд сумын засаг даргын чиглэл
8.	Элэгдлийг багасган, Халив-Дугатын үерийн усыг үр ашигтай урсахын тулд Халив-Дугатын голын өөрчлөлтийн сувгийн бүрэн бүтэн байдлыг сайжруулах; Өөрчлөлтийн баг бөх байдлыг үнэлэх болон элэгдэл ихтэй газруудыг тодорхойлохдоо хамтран баримт олж тогтоох судалгааг ашиглаж болно. Эрэг ёроолыг бэхжүүлэн, ус тогтохыг багасгах гэх мэт арга хэмжээг авбал зохистойг ГТЗ хамтран шийдэх;	Борооны улиралд	ОТ	(1) Халив-Дугатын голын өөрчлөлтийн сувгийн бүрэн бүтэн байдлыг сайжруулахын тулд хийгдсэн ажлын тайлан (2) Халив-Дугатын голын ус үерлэхэд голын ус чөлөөтэй урсах нөхцөл бүрдсэн байх	(1) Халив-Дугатын голын өөрчлөлтийн сувгийн бүрэн бүтэн байдлыг сайжруулахын тулд хийгдсэн ажлын тайланг МТ нотлох (2) Бороо орж, Халив-Дугатын гол үерлэсний дараа МТ (орчны малчдын хамт) гол чөлөөтэй урсаж буйг гэрчилж баримтжуулах	
9.	Усны хагалбарт тогтоол ус хуралдах, ууршихаас сэргийлэхийн тулд хаана ямар нь тохиромжтойгоос шалтгаалан нүхэн хоолой, нуман эсвэл хуягласан гарам зэрэг ус нэвтрүүлэн зайлуулах зохистой механизмийг бий болгох; Эдгээр газруудыг ГТЗ хамтран хянан үзэж; нөлөөллийг бууруулах ямар аргыг хаана хэрэглэх тухайд шийдвэр гаргах.	Борооны улиралд				
10.	Хаягдал Хадгалах Байгууламжийн (ХХБ) шүүрэлт буй эсэхийг Техникийн Хяналтын Хөндлөнгийн Зөвлөл (ТХХЗ) хянан үзэж, ХХБ-ийн зураг төсөлд оруулах өөрчлөлтийг санал болгон, урсгалын доод руу гарч болзошгүй нөлөөллийг судлан, үр дүнг бүх талуудад тайлагнах; ТХХЗ ГТЗ-д өгөх тайландаа голын доод руу учирч болзошгүй аливаа нөлөөллөөс зайлсхийх эсвэл бууруулахын тулд ОТ хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн ямар өөрчлөлт хийх хэрэгтэй тухай санал оруулах	2017 оны 3-р улиралд	Н. Эрдэнэбаяр, ОТ, Б. Алтангэрэл, ОНЗЗ, Ц.Гүнсмаа, МТ Д. Намсрай, МТ	(1) ТХХЗ-ийн хяналтын тайлан; (2) Урсгалын доод руу гарч болзошгүй нөлөөллийн судалгааны дүн, тайлан	Эдгээр тайлан, мэдээг ГТЗ-ийн хуралд танилцуулах	

11.1	Нэмэлт усны эх үүсвэрээр Уст баг мод карьерын хонхорт хиймэл цөөрөм, хөв байгуулж ургамалжуулах талаар ГТЗ хамтран ажиллах;		ОТ	Биологийн нөхөн сэргээлт бүрэн хийгдсэн тухай Аймгийн Уул уурхайн ашиглалт, дэд бүтэц, бусад үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг хүлээн авах ажлын хэсгийн акт	
11.2	Ургамалжуулалтын төлөвлөгөөг малчидтай хамтран боловсруулж үйл ажиллагааг хэрэгжүүлж, үр дүнд шинжилгээ хийх	2016 оны 5 сараас 2018 оны 8-р сар	Н. Эрдэнэбаяр, ОТ		Явцын тайланг ГТЗ-ийн хурлаар жилд нэг удаа танилцуулах
12.	МТ-аас санал болгосон бэлчээрийн нэмэлт мониторингийн цэгийг бэлчээрийн хамтын шинжилгээний багийн үнэлгээнд оруулж ашиглах;	2016 оны 8-р сар	Бэлчээрийн хээрийн судалгааны хамтарсан баг	Бэлчээрийн хээрийн судалгааны тайлан	
13.	Ундай голын сав газарт нутагладаг малчин өрхөд дараах нөхөн олговрыг олгох (Гол шалгуур: 2007 оны 1 сарын 1-нээс 2012 оны 12-р сарын 29-ны хооронд сумын бүртгэлд малчин өрхөөр бүртгэлтэй, Ундай голын ай сав газарт өвөлжөө хаваржаа эзэмшин амьдарч байгаа өрхүүд):	2017 оны 3-р улиралд эхлэх	ОТ		
13.1	Шалгуурын дагуу энэ бүсэд хамаарах малчин өрхийн нэрсийн жагсаалт гаргах	2017 оны 6-р сар	Ч. Намнансүрэн, Д. Намсрай, Ө. Баттогтох, Л. Батцэнгэл, Т. Насанбуян, МТ, Б. Эрдэнэбаяр, ОНЗЗ	Нэрсийн жагсаалт	
13.2	Ахмадын Хороотой хамтран Ундайн гол дагуух өрхүүдийн ахмад настангуудад “Уламжлалт мал аж ахуйн өв, мэдлэгээ залуучуудад таниулан түгээх, зөвлөх, уламжлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд” нь зориулж төсөл хэрэгжүүлж, Ундайн гол дагуу амьдардаг ахмадуудад урамшуулал олгох	2017 оны 6-р сарын 15	Батзориг, ОТ	1. Төслийн баримт бичигт заасны дагуу төсөлд хамрагдсан ахмадуудын тоо ... 2. Төслийн хүрээнд хамруулсан залуучуудын тоо ... 3. Хамрах хүрээ, төрөл	
13.2.1	Төслийн санал боловсруулж, ГТЗ-д танилцуулах		Батзориг, ОТ		
13.2.2	ГТЗ-өөр дэмжигдсэн төслийн санхүүжилт хүсч шийдвэрлүүлэх	2017 оны 3-р улиралд	О. Цэрэннадмид, ОТ		
13.2.3	Төслийг хэрэгжүүлж тайлагнах	2017 оны 4-р улиралд эхлүүлэх	Ахмадын Хороо		
13.3	Ажлын байранд мэргэжлийн ур чадварыг дадлагажуулан сургах ОТ-н сургалтанд давуу байдлаар хүмүүсийг хамруулах боломжийг судлаад хэлэлцэх;	2017 оны 7-р сард хэлэлцэх	О. Цэрэннадмид, ОТ Ж. Занабазар, ОНЗЗ	Сургалтанд хамрагдсан хүний тоо ... үүнээс ажилд орсон хүний тоо ...	Орон нутгийн ажил эрхлэлтийг дэмжих хамтарсан ажлын хэсгээс (Аймгийн засаг даргын орлогч ахласан) мэдээлэл авч ГТЗ-д танилцуулах
13.4	Магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуульд суралцаж буй малчдын оюутан хүүхдүүдийн сургалтын тэтгэлэг олгох – (тохиролцоонд хүрсэн өдрийн байдлаар оюутан байгаа хүүхдүүдийг нь төгстөл олгох) – Ингэхдээ голч оноо нь 2.7-оос дээш; Сум орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлийн суралцаж буй малчдын оюутан хүүхдүүдэд олгох		ОТ	Тэтгэлэг олгох хөтөлбөрийн шалгуур хангасан малчдын бүх оюутан хүүхдүүдэд сургалтын тэтгэлгийг олгож	Сум орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлийн талаар сумын ИТХ-н тэргүүлэгч гишүүд хэлэлцэж шийдвэр гарган Нэхэмжлэлийн Хороонд өгөх



Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээ # 2

13.4.1	Малчдын оюутан хүүхдүүдэд сургалтын тэтгэлэг олгох хөтөлбөр (шалгуур үзүүлэлт, суралцах чиглэл, тэтгэлгийн дээд хэмжээ гэх мэт.) боловсруулж ГТЗ-т танилцуулан дэмжүүлэх	2017 оны 6-7-р сард	О. Цэрэннадмид, ОТ	эхлэсэн байх,	
13.4.2	Тэтгэлэгт хамрагдах малчдын хүүхдийн нэрсийн жагсаалт, суралцаж буй сургуулийн нэр, суралцаж буй мэргэжлийн чиглэл, сурч буй түвшин, сурлагын голч онооны жагсаалт мэдээллийг гаргах	2017 оны 5-р сарын 15	Ч. Намнансүрэн, Л. Батцэнгэл, МТ, Б. Эрдэнэбаяр, ОНЗЗ		
13.4.3	Тэтгэлэгт хамрагдах хүсэлт хүлээн авч шийдвэрлэж эхлэх	2017 оны 8-р сараас эхлэх	О. Цэрэннадмид, ОТ		
13.5	Тогтвортой Амьжиргааны Хөтөлбөр хамтран боловсруулж хэрэгжүүлэх		ОТ		
13.5.1	<b>Төсөл 1: Амьдрах ухааны цогц сургалтын төсөл</b>				
13.5.1.1	Сумын насан туршийн боловсролын төвтэй хамтран төслийн санал боловсруулан ГТЗ-д танилцуулах	2017 оны 3-р улирал	Занабазар, Засаг даргын орлогч Танхилдулам, ОТ Ч. Намнансүрэн, МТ	Төсөл 1 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)	
13.5.1.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал			
13.5.1.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал	ОТ		
13.5.2	<b>Төсөл 2: Худаг засварын баг байгуулах төсөл</b>				
13.5.2.1	Энгийн уурхайн болон инженерийн хийцтэй уст цэг засварладаг баг байгуулах төслийн санал боловсруулан ГТЗ-д танилцуулах (орон нутгийн малчид болон мэргэжлийн байгууллага хамтарсан баг)	2017 оны 3-р улирал	Сүглэгмаа, МЭҮТ Баярбаатар, ОТ Ө. Баттогтох, МТ	Төсөл 2 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)	
13.5.2.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал			
13.5.2.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал	ОТ		
13.5.3	<b>Төсөл 3: Хороо засварын баг байгуулах төсөл</b>				
13.5.3.1	Орон нутгийн малчдаас бүрдсэн малын хороо засварын баг байгуулах төслийн санал боловсруулан ГТЗ-д танилцуулах	2017 оны 3-р улирал	Хүрэлбаатар, МЭҮТ Баярбаатар, ОТ Г. Мягмар, МТ	Төсөл 3 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)	
13.5.3.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал			
13.5.3.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал	ОТ		
13.5.4	<b>Төсөл 4: Малчны зах байгуулах буюу Малын гаралтай түүхий эдийг үйлдвэрлэгчдэд ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход дэмжлэг үзүүлэх төсөл</b>			Төсөл 4 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)	
13.5.4.1	Цогт-Цэций сум болон бусад сумдад байдаг малчны захын талаар судлаж ноос, ноолуур, сүү цагаан идээ, арьс ширийг үйлдвэрлэгчдэд хүргэх ханган		Занабазар, ОН Баярбаатар, ОТ Л. Батцэнгэл, МТ		Сумын бизнес эрхлэгчидтэй хамтарч боловсруулах, хэрэгжүүлэх

Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээ # 2

	нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход дэмжлэг үзүүлэх төслийн санал боловсруулан ГТЗ-д танилцуулах				
13.5.4.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал			
13.5.4.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал	ОТ		
13.5.5	<b>Төсөл 5: Малчдад хүрэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах төсөл</b>				
13.5.5.1	Сум дундын эмнэлэгтэй хамтран одоо хэрэгжиж буй Эрүүл малчин төслийн үйл ажиллагааг өргөжүүлэн төслийн санал боловсруулж ГТЗ-д танилцуулах	2017 оны 10-р сар	Гэрэлмаа эмч, Сум дундын эмнэлэг Танхилдулам, ОТ Т. Насанбуян, МТ	Төсөл 5 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)	
13.5.5.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал			
13.5.5.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 3-р улирал	ОТ		
13.5.6	<b>Төсөл 6: Малын тэжээлийн ургамал тариалах төсөл</b>				
13.5.6.1	Сумын хэмжээнд малын тэжээлийн ургамал тариалах төслийн санал боловсруулж ГТЗ-д танилцуулах (цаашид бие даан үйл ажиллагаа явуулах)		Сүглэгмаа, МЭҮТ Баярбаатар, ОТ Д. Намсрай, МТ	Төсөл 6 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)	
13.5.6.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал			
13.5.6.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал	ОТ		
13.5.7	<b>Төсөл 7: Хиймэл нуур цөөрөм, хур борооны ус цуглуулах хөв байгуулах</b>				
13.5.7.1	Баг тус бүрээр хөв байгуулах боломжтой байршлуудыг тогтоож, сэргээн тохижуулах шаардлагатай цэгүүдийг малчдын санал дээр үндэслэн тогтоох	2017 оны 3-р улирал	Сумын засаг захиргаа, Багийн иргэдийн хурал Малчдын төлөөлөл	Төсөл 7 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)	
13.5.7.2	Тогтоосон цэгүүд дээр судалгаа хийж, сэргээн тохижуулах төлөвлөгөө гарган ГТЗ-д танилцуулах		Хүрэлбаатар, МЭҮТ Баярбаатар, ОТ Т. Насанбуян		
13.5.7.3	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал			
13.5.7.4	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал	ОТ		

13.5.8	Төсөл 8: Малчдын хэрэглээний гүн өрмийн худгийг сэргээгдэх эрчим хүчинд холбоход дэмжлэг үзүүлэх;					
13.5.8.1	Тоноглох шаардлагатай гүн өрмийн худгуудын тоо, байршил тогтоож, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй холбох төслийн санал боловсруулан ГТЗ-д танилцуулах (хэрэглээ, ашиглагчийн байдал зэргийг харгалзана)	2017 оны 3-р улирал	Хүрэлбаатар, МҮЭТ Баярбаатар, ОТ Д. Наранхүү, МТ	Төсөл 8 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)		
13.5.8.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал				
13.5.8.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал	ОТ			
13.5.9	Төсөл 9: Залуу малчдад дэмжлэг тусалцаа үзүүлэх, “Залуу малчин” (35-аас доош насны) төсөл хэрэгжүүлэх (ХБ сумын 2024 он хүртэлх МААХХ-т тусгагдсан)			Төсөл 9 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)		
13.5.9.1	Аймгийн малчин хөтөлбөртэй уялдсан залуу малчдад хандсан сургалт, мэдээллийн төслийн санал боловсруулан ГТЗ-д танилцуулах	2017 оны 11-р сар	Хүрэлбаатар, МҮЭТ Баярбаатар, ОТ Ч. Намнансүрэн, МТ			
13.5.9.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх	2017 оны 3-р улирал				
13.5.9.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх	2017 оны 4-р улирал	ОТ			
13.5.10	Төсөл 10: Мал нядалгааны шугам барих, байнгын ажыллаагатай болох	2018	ОТ/Ханбогд сумын Засаг Захиргаа	Төсөл 10 хэрэгжиж эхэлсэн байх (Төслийн баримт бичиг, явцын тайлан)	Тогтвортой Амьжиргаа Хөтөлбөрийн хүрээнд энэ төслийн техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа хийх ажлыг оруулах	Хавсралт-Б-18-д заасан төсөл
13.5.10.1	Төслийн санал боловсруулан ГТЗ-д танилцуулах					
13.5.10.2	ГТЗ-ийн саналыг тусган төслийг сайжруулан боловсруулж ГТЗ-өөр дэмжүүлэх					
13.5.10.3	ГТЗ-ийн дэмжсэн төслийн санхүүжилтыг ОТ шийдэж хариуцсан баг хэрэгжүүлж эхлэх					
13.6.1	Одоогийн гэрээнд байгаа мониторингийг үе шаттайгаар орон нутгийн мониторингоор солих бодлого баримталж, орон нутгийн мэргэшсэн байгууллага, малчдыг мэргэжлийн мониторинг хийх түвшинд чадавхжуулах; Малчид чин сэтгэлээсээ оролцож, хариуцлагатай хандах нь мониторингийг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэхэд зайлшгүй чухал, иймд мониторингийн ажлыг цалин урамшуулалтай болгох; Оролцоог хангахын тулд хөтөлбөрүүд мал маллагааны хэв маягт тохирсон, малчид хянан баталгаажуулах боломжтой, шинжлэх ухааны үндэслэлтэй, итгэл үнэмшлийг хангасан, хүртээлтэй, найдвартай байлгахын тулд баримт хамтран олж тогтоох аргачлалыг ашиглан боловсруулж, хэрэгжүүлэх	2018 оны 1-р сараас эхлэх	С. Дорждэрэм, ОТ Б. Алтангэрэл, ОНЗЗ Д. Намсрай, МТ	Малчдын бүлэгтэй хамтын мониторинг хийлгэх гэрээ байгуулж ажиллаж эхэлсэн байх	1. Зөвхөн нэг малчдын бүлэгтэй гэрээ байгуулах бөгөөд малчдын бүлэг нь дотроо тодорхой төрлүүдээр мониторинг хийх дэд бүлгүүдэд хуваагдсан байж болно. 2. Урт хугацаанд мониторингийн дата мэдээлэлд шинжилгээ хийн зөвлөмж боловсруулах чадварыг бэхжүүлэх, энэ	

13.6.2	Орон нутгийн мониторингийн зорилго болон хамрах хүрээ, төрлийг тохирох (бэлчээр, хөрс, ургамалжилт, ус, тоос, зэрлэг ан амьтан, Ундайн гол, Халив Дугатын голын урсац, Хаягдал Хадгалах Байгууламжийн шүүрэл, урсацын доод тал руу гарч болзошгүй нөлөөлөл гэх мэт)	2017 оны 4-р улиралд эхлэх			чиглэлээр мэргэшсэн хүн бэлтгэхэд зорих	
13.6.3	Мониторингийн ажлын төлөвлөгөө (аргачлал) боловсруулж ГТЗ-д танилцуулах					
13.6.4	Мониторингийн мэдээ цуглуулах, боловсруулах, тайлагнах талаар малчдын бүлгийг сургаж чадавхжуулах					
13.6.5	Мониторингийн ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж ажиллах	2018 оны 1-р сараас эхлэх				
14	<u>Гидрогеологийн судалгаа (бэлчээрийн доорх усны нөөцийн судалгааг)</u> санхүүжүүлж мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	2017 оны 2-3-р улиралд	ОТ/ Ханбогд сум	Сумын нийт газар нутаг дахь бэлчээрийн усны нөөцийг тогтоосон зураглал (бусад тайлан мэдээ)	Уг судалгаа нь худаг барих, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэс суурийг бий болгоно. Судалгааны ажлын даалгаврыг ГТЗ хэлэлцүүлнэ.	Хавсралт Б-ийн #2-т заасан төсөл

ЭЦСКИЙН ХУВИЛГАА

Хавсралт А. Ундайн голын голидрол өөрчилсөнтэй холбогдуулан албан ёсоор малчдаас уучлал гуйж, уучлалын захидал



Но .....

2015 оны 03 сарын 20 өдөр

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН МАЛЧДАД

Хүлцэл очих нь

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Ундай гол дагуу нутаглаж, амьдрал ахуйгаараа салшгүй холбоотой байж ирсэн малчид Та бүхэнд энэ захидлыг хаягласан юм.

Та бүхний он удаан жил амьдран нутаглаж жилийн дөрвөн улирлын турш мал сүргээ маллаж, ирсэн газар нутагт үйл ажиллагаа эрхэлж буйгаа “Оюу толгой” компани сайтар ойлгодог.

Анх 2013 онд нутгийн малчид тус компанийн эсрэг гомдол гаргаж, Ундай гол дагуу нутгийн байгалийн онцлог, бэлчээр ус, хүн ардын аж амьдралын тухай бидэнд байнга хэлж, анхааруулж, зовлож ирсэн.

“Оюу толгой” ХХК энэ бүхнийг бидэнд уйгагүй хэлж сургаж, цөхрөлтгүй зааж залруулж ирсэн тэдгээр малчдад талархаж байна. Уурхайгаас болж Ундай гол дагуу нутагладаг малчид болон Ханбогд суманд аж төрдөг нийт ард иргэдийн аж амьдралд олон төрлийн өөрчлөлт авчирсныг бид ойлгож байна.


Нэн ялангуяа уурхайн үйл ажиллагаанаас болж уурхайн орчимд малаа бэлчээрлүүлдэг малчдын аж амьдралд өөрчлөлт орж, улмаар Ундай голын хувь заяа, мал сүрэг, үр хойчийнхоо ирээдүйд илүү санаа зовж байгааг бид ойлгож байна.

Голын урсгалыг хамгаалахын тулд бид Ундай голын дагууд инженерийн ажил гүйцэтгэх шаардлагатай болсон юм. Урсацыг хамгаалах энэ ажил төлөвлөгөөний дагуу амжилттай явагдсан гэдэгт бид бүрэн итгэлтэй байгаа боловч энэ ажлын талаар Та бүхэнд бүрэн гүйцэд тайлбарлаж, багийн хурал дээр ярьж зөвлөлдөөгүйдээ хүлцэл очье. “Оюу толгой” компани нутгийн иргэдийг почирдуулж, санааг нь зовоосондоо, мөн яаруу түргэн хөдөлж, буруу өдөр ажил эхэлсэндээ уучлалт хүсч байна.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд тус компани Ханбогд сум болон малчидтай илүү идэвхтэй хамтран ажиллаж ирлээ. Цаашид Хамтын ажиллагааны гэрээний дор байгуулагдаж буй зөвлөлдөх хороодоор дамжуулан энэхүү хамтын ажиллагаагаа илүү үр дүнтэйгээр өргөжүүлэн хөгжүүлнэ. Сумын иргэд, малчид энэ хороодтой идэвхтэй хамтран ажиллаж, мэдээлэл солилцон, “Оюу толгой” компани Ханбогд суманд зөв үйл ажиллагаа явуулахыг дэмжин ажиллана гэдэгт найдаж байна.

Хүндэтгэсэн,

ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



АЙВЕН ВЕЛЛА

Хавсралт Б: Нийтийн нөхөн олговорын хүрээнд ХБ сумын 2024 он хүртэлх МААХХ-ийн хүрээнд ОТ-н хамтын ажиллагааны гэрээний хүрээнд санхүүжүүлэхээр тохирсон ург хугацаанд хэрэгжүүлэх төслүүд

#	Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажил	Хэрэгжи х хугацаа	Удирдан зохион байгуулах газар	Хамтран зохион байгуулах	Төсөв, сая
<b>Мал аж ахуйн салбарын хөгжлийн суурь болох бэлчээр, усны нөөцийн цогц судалгаа хийж тэдгээрт үндэслэн сумын бэлчээр ашигдалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх</b>					
1	Бэлчээрийн даац, чанарын үнэлгээ хийх, тэжээлийн нөөц тодорхойлох, чадамжийг шинэчлэн тогтоох	2016-2017 он	Өмнөговь аймгийн ХХААГ	Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумдын ЗДТГ. Мэргэжлийн байгууллага	500.0
2	Сумын хэмжээнд уст цэгийн нэгдсэн тооллого хийж үнэлгээ өгөх, мэргэжлийн байгууллагаар гидрогеологийн хайгуул тандагт хийлгэж нөөц тогтоолох;	2016-2017 он	Өмнөговь аймгийн ХХААГ	Ханбогд сумын ЗДТГ. Мэргэжлийн байгууллага	900.0
3	Малын тэжээлийн нэгдсэн агуулахтай болж, нөөц бий болгох, мал сүргийг эрсдлээс хамгаалах сан бүрдүүлж	2018-2020 он	Ханбогд сумын ЗДТГ.	Аймгийн онцгой байдлын газар	300.0
4	Усны нөөцийн судалгааг үндэслэн шинээр худаг гаргах, уст цэгийг сэргээн засварлах;	2019-2022 он	Ханбогд сумын ЗДТГ.	Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумдын ЗДТГ. Мэргэжлийн компани	500.0
<b>Малын эрүүл мэндийн нэгдсэн төвийг байгуулж, мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, шаардлагагай тоног төхөөрөмж, програм хангамж бусад материалаар хангах</b>					
5	Малын эрүүл мэндийн нэгдсэн төв (арчун цэвэр, эрүүл ахуйн болон байгаль орчны ийнжээгээдий лаборатори бүхий)-ийн техник эдийн засгийн үндэслэл болон барилгын зураг төсвийг боловсруулах;	2016 он	Ханбогд сумын ЗДТГ	NCCS компани. Улсын мал эмнэлэг, арчун цэврийн төв лаборатори	35.0
6	Малын эрүүл мэндийн нэгдсэн төвийн барилга байгууламжийг барьж ашигдалтанд оруулах;	2016-2017 он	Өмнөговь аймгийн ХХААГ	Ханбогд сумын ЗДТГ. Барилгын компани	1,350.0
7	Малын эрүүл мэндийн төвийн лабораторит ажиллах арчун цэвэр, эрүүл ахуйн болон байгаль орчны чиглэлээр мэргэжилтнүүдийг бэлтгэх	2017-2019 он	Өмнөговь аймгийн ХХААГ	Ханбогд сумын ЗДТГ. ХААИС	100.0
<b>Мал маллагааны уламжлалт арга-барилгыг сэргээх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, мэрэгжилтэнүүдийг чадваржуулах</b>					
8	Сумын хүн эмнэлгийн салбартай хамтран "Эрүүл малчин" бичиг төсөл боловсруулж хэрэгжүүлэх	2016 он	Ханбогд сумын Сум дундын эмнэлэг	Ханбогд сумын ЗДТГ Аймгийн ЭМГ	100.0
9	Салбарын мэргэжилтнүүдэд орчин үеийн программ хангамжуудыг ашиглахад сургах, мал аж ахуйн үйлдвэрлэлийн менежментийн болон технологийн ур чадварыг эзэмшүүлэх;	2017-2018 он	Өмнөговь аймгийн ХХААГ	Ханбогд сумын ЗДТГ. ХААИС Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв	150.0
10	Ахмад малчидтай хамтран малчдын залуу халааг бэлтгэх, бүлэг, хоршоолын ирээдүйн чадварлаг удирдагч, менежерүүдийг бий болгох "Залуу малчин" төсөл хэрэгжүүлэх;	2019-2022 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ. Хоршооллын сургалт мэдээллийн төв	250.0

Малчдын Гомдлыг Барагдуулах Гэрээ # 2

11	Бэлчээр ашиглалт, малыг уламжлалт болон дэвшилтэт технологийн дагуу маллах, малын эрүүл мэнд, ашиг шимийг сайжруулах, байгалийн эрсдлээс хамгаалах мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх сургалтыг шат дараатай зохион байгуулах;	2023-2025 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв	275.0
<b>Малын эрүүл мэнд, үйлдэрлэг байдлыг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх</b>					
12	Мал аж ахуйн салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, программ хангамжтай болгох замаар сумын мал эмнэлэг, үржлийн тасаг, үйлчилгээний нэгжүүдийг бэхжүүлэх	2017-2020 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ.	140.0
13	Сумын бог малын бүх хээлтүүлэгчийг мэргэжлийн байгууллагын мэдэлд /хяналт/ авах, сайн чанарын өсвөр хээлтүүлэгч бойжуулах "Цөм сүрэг" төсөл хэрэгжүүлэх	2018-2022 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ. Малын удмын сангийн үндэсний төв	450.0
14	Сумын байгаль, цаг агаарын нөхцөлд тохирсон ашиг шим сайтай мал үржүүлэх, "Эрчимжсэн мал аж ахуй" төсөл хэрэгжүүлэх;	2020-2022 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв	300.0
<b>Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөгжүүлэх</b>					
15	Торомны ноосыг самнаж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хонь, тэмээг цахилгаан хайчаар хяргах технологи нэвтрүүлэх;	2018-2019 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ.	300.0
16	Ингэний сүүг боловсруулан эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг дэмжих	2019-2020 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ.	300.0
17	Техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан малын гаралтай түүхий эдийг боловсруулах бусад үйлдвэрлэлийг дэмжих	2020-2021 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ.	400.0
18	Мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах дэвшилт технологи бүхий үйлдвэр бий болгох;	2021-2022 он	Өмнөговь аймгийн ХХААГ	Ханбогд сумын ЗДТГ.	500.0
19	Бүсийн сумдын тэмээ, хонины ноосыг боловсруулах үйлдвэр байгуулж зарим төрлийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих	2022-2024 он	Ханбогд сумын ЗДТГ	Өмнөговь аймгийн ХХААГ.	400.0
<b>Нийт дүн</b>					<b>5900.00</b>